



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/208

Улаанбаатар хот

Г МУИС-д профессор, багш ажиллуулах  
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны 1.7 дугаар зүйл, Эрдмийн зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 20; 04 дүгээр сарын 09-ний өдрүүдийн хуралдаануудын шийдвэрүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-д профессор, багш ажиллуулах журмыг хавсралтаар баталж, 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


2. Тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/414 дүгээр тушаал, 2012 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 652 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “МУИС-ийн багшийн ажлын нэгдсэн үнэлгээний /аттестатчиллын/ журам”-ыг тус тус 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болгосугай.

3. Тушаалыг нийтэд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг), Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг), Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал (Ч.Ундрям), бүрэлдэхүүн сургуулийн захирал (Д.Заяабаатар, Н.Баатарбилэг, Ч.Энхбаяр, Ж.Эрдэнэбулган, С.Баттулга), харьяа сургуулийн захирал (П.Оюунбилэг, Т.Энх-Амгалан), Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (Д.Бадамдаш) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ПРОФЕССОР, БАГШ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. МУИС-д профессор, багш ажиллуулах, багшийн эрх, үүрэг, түүнд тавигдах шаардлага, багшийн мэргэжлийг дээшлүүлэх, мэдлэг чадварыг үнэлэх, багшийн албан тушаалын зэрэглэлийг тогтоох, профессор, дэд профессор цол олгох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, МУИС-ийн дүрэмд нийцүүлэн зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэ журмаар зохицуулаагүй асуудлыг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, МУИС-ийн дүрэм, журам болон эрх зүйн бусад актаар зохицуулна.

### Хоёр. МУИС-ийн профессор багшид тавих шаардлага

2.1. МУИС-ийн профессор, багш (цаашид багш гэнэ) нь онолын гүнзгий мэдлэгтэй, оюуны өндөр чадамжтай, мэдлэг, чадвараа дээшлүүлэхийн төлөө байнга санаачилгатай ажилладаг, эрдэм шинжилгээ, сургалтын ажлыг хослуулан гүйцэтгэх чадвартай, судалгааны болон заах арга зүй эзэмшсэн, судалгаа, сургалтын ажилдаа мэдээллийн технологийн ололтыг ашигладаг, залуу үеийг төлөвшүүлэх, амьдрах ухаанд сургах үйлсэд чин сэтгэлээсээ ханддаг, зөв төлөвшсөн, багш, судлаачийн ёс зүйг эрхэмлэдэг байна.

2.2. МУИС-ийн бакалаврын түвшинд хичээл заах багш магистраас доошгүй, ахисан түвшний сургалтад хичээл заах багш докторын зэрэгтэй байна.

2.3. Бакалаврын түвшний мэргэжлийн хичээл, магистр, докторын хичээл заадаг багш тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийж, хоёроос доошгүй гадаад хэлээр мэргэжлийн ном сэтгүүл ашиглах чадвартай байна.

2.4. Гадаадад судалгаа хийх, зочин багшаар ажиллах, мэргэжил дээшлүүлэх, суралцахаар явах багшийн сургуультай хийх гэрээний хугацаа, сунгалт, хариуцлага зэрэг нь "МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журам"-аар зохицуулагдана.

2.5. Үндсэн мэргэжлийн хичээл заадаг багш МУИС-д багшаар томилогдсоноос хойш 12 жилийн дотор докторын зэрэг хамгаалах шаардлагатай. Докторын зэрэг хамгаалаагүй боловч бусад бүх болзлыг биелүүлсэн (докторын сургалтын багц цагийг бүрэн биелүүлсэн) тохиолдолд хөдөлмөрийн гэрээг 1 хүртэл жилээр сунгаж болно. Тэнхимд тухайн мэргэжлийн багш хүрэлцээгүй, заалгах цаг хүрэлцээтэй

нөхцөлд тэдгээр багшийг холбогдох тэнхим, салбар, бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн зөвхөн сургалтын цаг биелүүлэх Нөхцөлөөр ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд эрдэм шинжилгээний багц цагийг сургалтын багц цагаар шилжүүлж гүйцэтгүүлнэ. Энэ шаардлагыг хангаагүй нөхцөлд МУИС-д үргэлжлүүлэн багшшуулах боломжгүй гэж үзнэ.

1117144746  
УХД0072 9104399

2.6. Багшийн ажлын нэгдсэн үнэлгээнд хангалтгүй дүн үзүүлж, эрдэм шинжилгээ, сургалт заах аргын ур чадварын хувьд өсөөгүй, цаашид багшаар ажиллуулах боломжгүй болохыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлөөр хэлэлцэж шийдсэн тохиолдолд хичээлийн жилийн эцэст тухайн багштай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажлаас чөлөөлнө.

2.7. Багшийн тэтгэвэр тогтоолгох насын дээд хязгаар Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар байна. Тэтгэвэр тогтоох насанд хүрсэн багшийн хөдөлмөрийн гэрээг тухайн хичээлийн жилийн эцэст дуусгавар болгож гэрээг цуцална.

### Гурав. Багшийн эрх

Багш нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, МУИС-ийн дүрэмд зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

3.1. Сургалт явуулахад зайлшгүй шаардагдах материаллаг орчин нөхцөл, мэдээллээр хангагдах, МУИС-ийн нэрээр, эсвэл МУИС-тай хамтарсан судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэхдээ МУИС-ийн материаллаг орчныг ашиглах;

3.2. Бүтээлийн чөлөө авах, бичиж туурвисан бүтээлээ хэвлэн нийтлүүлэхэд дэмжлэг авах;

3.3. МУИС-ийн докторантурт суралцахад сургалтын төлбөрийн 60 хувь хүртэл хөнгөлөлт өдлэх;

3.4. МУИС-ийн үйл ажиллагааны талаар сургуулийн захиргаанд санал дүгнэлтээ илэрхийлэх;

3.5. Түр сургалтад суралцах болон бусад хэлбэрээр мэргэшлээ дээшлүүлэхэд дэмжлэг авах;

3.6. МУИС-ийн дүрэм, журам, хөгжлийн стратегийн бодлого, төлөвлөгөө боловсруулах, хэлэлцэх, хэрэгжүүлэх, хяналт тавих бүхий л үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх;

3.7. Хичээлийн жил бүр хийсэн ажлаа дүгнүүлэн хууль ёсны амралт өдлэх, шагнал урамшуулал авах (үүнийг тусгай журмаар зохицуулна);

3.8. МУИС, их дээд сургуулийн консорциумаас зарладаг шилдэг багш, шилдэг судлаачийн уралдаан зэрэгт оролцох, шагналд тодорхойлогдох, шагналыг дагалдуулдаг урамшуулал авах;

3.9. МУИС-ийн Оюуны өмчийн талаар баримтлах бодлого, Технологи дамжуулах журамд заасны дагуу судалгааны үр дүнгээ хамгаалуулах, эзэмших, эдийн засгийн эргэлтэд оруулах, эрхийн шимтгэл орлогоос хувь хүртэх, гарaanы компани үүсгэн байгуулах;

3.10. Холбогдох журамд заасны дагуу албан хэрэгцээнд МУИС-ийн нэр, лого, барааны тэмдгийг ашиглах.

3.11. Судалгааны ажлын нийтлэг чиглэл, сонирхол, хамтарсан эрдэм шинжилгээний төсөлт ажил хэрэгжүүлэх шаардлагаар нэг багш үндсэн харьяаллын тэнхимээс гадна өөр бүрэлдэхүүн/салбар сургууль, бусад **НЭГЖИД** давхар харьяалалтай ажиллаж болно. Давхар харьяалалтай багшийн сургалтын цагийн ноогдол үндсэн харьяаллын бүрэлдэхүүн/салбар сургууль, тэнхим дээр тооцогдоно.

3.12. Давхар харьяалалтай багш хамтарсан судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний төсөлт хэрэгжүүлэхээс бусад асуудлаар үндсэн харьяаллын тэнхимдээ ажиллаж, МУИС-ийн төлөөллийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг эдэлнэ<sup>1</sup>.

3.13. МУИС-д зочин профессороор ажиллаж буй гадаадын харьят иргэн тус сургуулийн төлөөллийн байгууллагыг сонгох, сонгогдох үйл ажиллагаанд оролцооос бусад эрхийг үндсэн багшийн нэгэн адил эдэлнэ.

### Дөрөв. Багшийн үүрэг

Багш нь дээр дурдсан боловсролын тухай хуулиуд, МУИС-ийн дүрэмд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 4.1. МУИС-ийн дүрэм, журам, тушаал шийдвэрийг биелүүлэх;
- 4.2. Хичээлийг онолын өндөр түвшинд чанартай зааж, суралцагчийн мэдлэгийг бодитой үнэлэх;
- 4.3. Бие даасан болон хамтарсан судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний төсөлт ажил гүйцэтгэх, зөвлөхөөр ажиллах, эрдэм шинжилгээний ажлыг удирдах, зөвлөгөө өгөх;
- 4.4. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, суралцагчийн бие даан суралцах хэрэглэгдэхүүн, ном суралцах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлэх, суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх сорилго боловсруулах, цахим журнал, багшийн ажлын дэвтрийг тогтмол хөтлөх;
- 4.5. Өөрийн зааж буй хичээлийн тодорхойлолт, суралцагчдын дүн, хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалт хариуцсан нэгжид шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, сургалтын цахим мэдээллийн санд оруулах;
- 4.6. Суралцагчийг зөв төлөвшүүлэхэд үлгэрлэн, суралцагчид үйлчлэх ажилд идэвхтэй оролцох;
- 4.7. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, тэнхимиийн эрхлэгчтэй тохиролцсоноор өвчтэй, чөлөөтэй болон томилолтоор явсан багшийн хичээлийг орлон заах;

<sup>1</sup> Энэ заалт ахисан түвшний сургалт хариуцсан нэгжид хамаарахгүй.

4.8. Эрдэм шинжилгээ, сургалтын болон бусад ажлаа тайлагнаж, холбогдох хугацаанд үнэлүүлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх талаар санаачилгатай ажиллаж, өөрийн мэргэжлийн салбарт гарсан шинжлэх ухааны шинэ нээлт, ололт амжилттай танилцаж зааж буй хичээлдээ тусгадаг байх;

4.9. Бусад багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх ~~1111474~~  
~~УХДЛ0072910430~~ ажиллагааг дэмжих, ажлыг үнэлэхэд оролцох, их сургуулийн нийгэмд гүйцэтгэх үүргийн дагуу төрөл бүрийн түр сургалт, сурталчилгаа явуулахад оролцох буюу зохион байгуулах;

4.10. Удирдлагын зүгээс даалгасан ажил үүргийг биелүүлэх, чанарын хяналт шалгалтад оролцох, үнэлгээний, багшлах, судалгаа шинжилгээний болон нийгмийн чиг үүрэгтэй холбоотой асуудал боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах;

4.11. Тотоосон хугацаанд өөрийн үнэлгээний тайлан бичиж, багшийн ажлын нэгдсэн үнэлгээнд хамрагдах;

4.12. Багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөө боловсруулан тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургуулийн төлөвлөгөөнд тусгаж, ажлын байран дээр тасралтгүй хөгжих;

4.13. Байгууллагын соёл, хэм хэмжээг хүндэтгэн судлаач, багш, хувь хүний хувьд суралцагч, эрдмийн хамт олон болон нийгэмд академик мэргэжлийн хандлага төлөвшүүлэгч байх;

4.14. Үндсэн үүрэгт ажлаа зохих ёсоор гүйцэтгэхэд ажлын цагийг бүрэн зарцуулах, МУИС-ийн ашиг сонирхолд үл нийцэх буюу багшийн үүрэгт ажлаа гүйцэтгэхэд харшлах ажил болох бусад их, дээд сургуульд үндсэн болон гэрээт, цагаар багшлахгүй байх, МУИС-д хөдөлмөрийн гэрээгээр үндсэн багшаар ажиллаж буй багш МУИС-ийн харьяллаас өөр байгууллагад үндсэн ажилтнаар ажиллахгүй байх. Хэрэв нэмэлт ажил хийхийг хүсвэл бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиралд мэдэгдэж албан ёсоор зөвшөөрөл авах (зөвшөөрлийг МУИС-ийн өмнө багшийн зүгээс хүлээсэн үүргээ биелүүлэхэд харшлахгүй нөхцөлд олгоно, зөрчсөн тохиолдолд холбогдох журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ).

#### Тав. МУИС-д шинээр багш авах

5.1. Энэ журмын 2 дугаар бүлэгт заасан МУИС-ийн багшид тавигдах шаардлагыг хангасан иргэнийг үндсэн багшаар авч ажиллуулна.

5.2. Багшийн сонгон шалгаруулалтыг хичээлийн жилд 1-2 удаа, улирлын хичээл эхлэхээс өмнө зохион байгуулна. МУИС-д багшийг дараах 2 хэлбэрээр авч ажиллуулна. Үүнд:

- Багшид тавих шаардлага хангасан хүнийг сонгон шалгаруулалтаар авах;
- Өндөр мэргэшлийн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүйгээр авч ажиллуулах.

## *A. Багшийг сонгон шалгаруулалтаар авах*

5.3. Багшийг сонгон шалгаруулалтаар авахад дараах зарчмыг баримтална.  
Үүнд: Багшийн сонгон шалгаруулалтыг Захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж хариуцан зохион байгуулах ба сонгон шалгаруулалтын зарыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн холбогдох тэнхим, захиргааны зөвлөлийн шийдвэрлиг үндэслэн шалгалт эхлэхээс гурваас доошгүй долоо хоногийн өмнө үндэсний өдөр тутмын сонин болон сургуулийн цахим хуудсаар нээлттэй зарлана.

1117144746  
УХД0072 9104399

5.4. Сонгон шалгаруулалтад оролцогчид ажил байдлын тодорхойлолт, төрийн албан хаагчийн анкет, боловсролын диплом болон иргэний үнэмлэхийн хуулбар, эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт, мэргэжлийн ур чадвар, багаар ажиллах чадвар, хувь хүний төлөв байдал, мэргэжлийн ёс зүй зэргийг тодорхойлсон холбогдох мэргэжлийн эрдэмтний тодорхойлолт зэрэг шаардлагатай материалыг бүрдүүлнэ.

5.5. Бүртгэлийг сонгон шалгаруулалтын зард заасан хугацаанд Захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж эрхлэн явуулах ба бүртгэлийн дугаар, овог нэр, төгссөн сургууль, холбоо барих утас, цахим хаяг, бүртгэсэн огноо, цагийг тэмдэглэнэ. Сонгон шалгаруулалтад орох иргэдэд энэхүү журмыг болон шалгалт авах чиглэл, дүгнэх журмыг урьдчилан танилцуулна.

5.6. Сонгон шалгаруулалтад орох болзол хангаж, бүртгүүлсэн иргэдээс бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар байгуулсан 3-5 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн багш нар оролцсон шалгаруулах комисс мэргэжлийн шалгалт (амаар болон бичгээр), ярилцлага зохион байгуулж, эрдэм шинжилгээний бүтээлд нь үнэлгээ өгнө. Шалгалтын материалд комиссын гишүүн нэг бүр үнэлгээ өгч, дунджаар нэгдсэн үнэлгээг гарган, комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Комиссын үнэлгээний дундаж 75 ба түүнээс дээш бол мэргэжлийн шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

5.7. Мэргэжлийн шалгалтад тэнцсэн иргэдээс англи хэлний шалгалт авах бөгөөд шалгалтад 60 болон түүнээс дээш хувийн үнэлгээ авсан бол тэнцсэнд тооцно. Олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэдэг түвшин тогтоо шалгалтын (TOEFL, IELTS, TOEIC зэрэг) 60 ба түүнээс дээш хувийн оноотой бол шууд тооцуулж болно. Гадаад хэлний багшаар авахад англи хэлнээс гадна монгол хэлний нэмэлт шалгалт авна. Англи хэлний шалгалтыг албан ёсны шалгалтын эрх бүхий гаднын байгууллагаар авхуулна.

5.8. Сонгон шалгаруулалтад тэнцэж багшаар ажиллах болзол хангасан нэр дэвшигчийг холбогдох тэнхим болон бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, МУИС-ийн захирлын тушаалаар ажилд томилно.

5.9. Сонгон шалгаруулалтаар шинээр авч байгаа багшийг хичээлийн жилийн нэг улирлын хугацаанд туршилтаар ажиллуулсны дараа холбогдох тэнхим, салбар, бүрэлдэхүүн/салбар сургуулийн саналыг үндэслэн үргэлжлүүлэн ажиллуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Энэхүү заалт дадлагажигч багшид нэгэн адил хамаарах ба туршилтын хугацаа дадлагажигч багшийн зэрэглэлд ажиллах хугацаанд багтана.

5.10. МУИС-д багшилж байгаад энэхүү журмын 2.4-т заасны дагуу гэрээ байгуулан докторантурт элсэн амжилттай суралцаж, эрдмийн зэргээ хамгаалсан болон өндөр хөгжилтэй оронд судлаач, зочин багшаар ажиллаж байгаад ирсэн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүйгээр багшаар ажиллуулж болно.

**Б. Өндөр мэргэшлийн эрдэмтнийг ажиллуулах**

1117144746  
УХД0072 9104399

5.11. Эрдэм шинжилгээний бүтээлзэрээ тухайн салбартаа олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгдсэн эрдэмтнийг (профессор эсхүл дэд профессор цолны шаардагдах оноог бүрэн хангасан) сонгон шалгаруулалтгүйгээр дэд профессор, профессорын зэрэглэлд ажиллуулж болох бөгөөд үүний тулд энэ тухай тэнхимийн шийдвэр, хурлын тэмдэглэлийг үндэслэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлөөр хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

5.12. Өндөр мэргэшлийн эрдэмтнийг авч ажиллуулахдаа их сургуулийн судалгааны бүтцийг ашиглан хамтарсан эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх, танхимиын болон цахим хэлбэрээр хичээл заалгаж болох бөгөөд тухайн судлаач гадаадад багшилж байгаа тохиолдолд тухайн мэргэжлийн тэнхимд давхар харьяалалтай байж болно.

5.13. Өндөр мэргэшлийн эрдэмтнийг авч ажиллуулахдаа шинээр авч байгаа багштай адил хичээлийн жилийн нэг улирлын хугацаанд туршилтын хугацаагаар ажиллуулсны дараа холбогдох тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургуулийн саналыг үндэслэн үргэлжлүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

**Зургаа. Багшийн мэргэжлийг дээшлүүлэх**

МУИС-д идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа багш мэргэжлээ дээшлүүлэхэд сургуулиас дараах хэлбэрээр дэмжлэг авч болно. Үүнд:

6.1. Гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай МУИС-ийн байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хүрээнд мэргэжлээ дээшлүүлэх, хамтарсан судалгааны ажилд оролцох;

6.2. Ажил үүргийн дагуу гадаадад томилолтоор ажиллах, дотоодод аж ахуйн нэгж, төрийн байгууллагад ажиллан практик дадлага олж авах, туршлага судлах;

6.3. Докторантурт суралцах, эрдэм шинжилгээний ажлын бүтээлийн чөлөө авах;


6.4. МУИС-д зохиогддог гадаад хэлний ахисан түвшний түр сургалт, сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын курст хамрагдахад санхүүгийн дэмжлэг авах;

6.5. Багшлах болон эрдэм шинжилгээний ажилд авьяас, сонирхолтойгоо харуулсан цаашид МУИС-д тогтвортой ажиллах багшийг гэрээний үндсэн дээр (сургууль, багш хоорондын гэрээ) гадаадын өндөр зэрэглэлтэй сургуулийн докторын сургалтад МУИС-ийн захиалгаар хамруулах, хамтын судалгааны ажил хийлгэх хэлбэрээр дэмжих зэрэг болно.

## **Долоо. Багшийн албан тушаалын зэрэглэл, түүнд тавих шаардлага**

7.1. МУИС-ийн багш нарыг тухайн салбар, хөтөлбөр, мэргэжлийн чиглэлээр хийж буй судалгаа, сургалтын ажлын чанар, үр дүнг харгалzan:

- а) профессор,
- б) дэд профессор,
- в) ахлах багш,
- г) багш,
- д) дадлагажигч багш гэсэн албан тушаалын 5 зэрэглэлд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулна.



7.2. Дадлагажигч багшийн зэрэглэлд шинээр авч буй магистрын зэрэгтэй багшийг 1-1.5 жилийн хугацаагаар ажиллуулна. Дадлагажигч багш тусгай төлөвлөгөөтэй ажиллаж, заах хичээлдээ бэлтгэх, туршлагатай багш нарын хичээлд суух, их дээд сургуулийн сургах арга зүйн курст суралцах үүрэгтэй. Дадлагажигч багш мэргэжлээ гүнзгийрүүлэн эзэмших, судалгаа, сургалтын арга барил, гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх төлөвлөгөө гаргаж, ажиллах хугацаандаа ажлын тайлангаа тэнхимийн хурлаараа хэлэлцүүлж үнэлүүлнэ.

7.3. Багшийн зэрэглэлд багшлах ажлын дадлага, өөрийн заадаг хичээлийн агуулга, арга зүйг боловсруулах чадвартай, заах арга зүй эзэмшсэн, МУИС-д ажилласан дадлагажигч багшийг тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургуулийн саналыг үндэслэн дэвшүүлэн ажиллуулна. Эрдэм шинжилгээний бүтээлтэй, багшлах ажлын зохих туршлагатай буюу их, дээд сургуульд 3-аас доошгүй жил үндсэн багшаар ажилласан хүнийг багшийн зэрэглэлд ажиллуулж болно.

7.4. Ахлах багшийн зэрэглэлд тухайн мэргэжлийн салбарын сургалтын агуулга, арга зүйг бүрэн эзэмшсэн, сургалтад шинэ арга технологи нэвтрүүлэн ажилладаг; сургах арга зүй, суралцагчтай ажиллах туршлагатай, МУИС-д 10-аас доошгүй жил багшилсан багш болон шинээр ажилд авч буй эрдмийн зэрэгтэй хүнийг ажиллуулна. Докторын зэрэг хамгаалсан багшийг ахлах багшаар шууд дэвшүүлэн ажиллуулж болно.

7.5. Профессорын болон дэд профессорын зэрэглэлд тус сургуулийн үндсэн чиг үүрэг болох эрдэм шинжилгээ, сургалтын ажлыг шинжлэх ухааны өндөр түвшинд цогц байдлаар гүйцэтгэн удирдан зохион байгуулж, гэрээгээр хүлээсэн ажил үүргээ бүрэн хариуцах чадвартай, нэр хүндтэй судлаач багшийг шалгаруулж ажиллуулна.

7.6. Профессор, дэд профессорын зэрэглэлд тавигдах ерөнхий шаардлага:

7.6.1. Докторын зэрэгтэй байх, эрдэм шинжилгээний ажил тогтмол гүйцэтгэдэг байх;

7.6.2. Судалгааны төсөл удирдан хэрэгжүүлдэг, оролцон гүйцэтгэдэг байх;

7.6.3. Судалгааны ажлын үр дүнгээ олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх;

7.6.4. Сурах бичиг, сургалтын материал, гарын авлага хэвлүүлсэн байх;

- 7.6.5. Сургалтын агуулга, технологийн шинэ арга барил эзэмшсэн;
- 7.6.6. Бакалаврын түвшний өрөнхий суурийн эсхүл мэргэжлийн суурийн хичээл заадаг;

7.6.7. Магистрант, докторантын судалгааны ажлын удирдагч байж, сургалтын үйл ажиллагааны 3 багц цагаас доошгүйг магистр<sup>47</sup> докторын түвшний сургалтанд хичээл зааж биелүүлдэг байх (гадаад хэлний сургалтын төв, биеийн тамирын тэнхимиийн багш наарт энэ заалт хамаарахгүй).

7.7. Профессор, дэд профессорын зэрэглэлд тавигдах тусгай шаардлага:

Дэд профессорын зэрэглэлд ажиллах багш дээрх өрөнхий шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

7.7.1. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 5-аас дээш жил ажилласан байх;

7.7.2. Олон улсын мэргэжлийн сэтгүүлд бүтээлээ хэвлүүлдэг байх;

7.7.3. Эрдэм шинжилгээний төсөл удирдан гүйцэтгэдэг, эсвэл голлох судлаачаар оролцож МУИС-д мөнгөн болон материаллаг орлого оруулсан байх;

7.7.4. Суралцагчийн бие даан суралцахад зориулсан сургалтын материал, гарын авлага бичиж, хэвлүүлсэн буюу цахим хуудсанд байрлуулсан байх;

7.7.5. Магистрантын эрдэм шинжилгээний ажлыг удирдаж хамгаалуулсан, эсвэл удирдагчаар ажилладаг байх;

7.7.6. Магистрант, докторантыг сургалт, судалгаа /төсөл, хөтөлбөр, гэрээт ажил/-ны туслахаар ажиллуулдаг байх.

Профессорын зэрэглэлд ажиллах багшид дараах тусгай шаардлагыг тавина:

7.7.7. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 9-өөс дээш жил ажилласан байх;

7.7.8. Докторантын эрдэм шинжилгээний удирдагчаар ажилладаг байх;

7.7.9. Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлдэг байх<sup>2</sup>;

7.7.10. Гадаад, дотоодын санхүүжилт бүхий эрдэм шинжилгээний төсөл удирдан хэрэгжүүлж, түүндээ магистрант, докторантуудыг судалгаа, сургалтын туслахаар ажиллуулдаг байх;

7.7.11. МУИС-д судалгааны хөрөнгө оруулалтыг мөнгөн болон материаллаг хэлбэрээр оруулсан байх;

7.7.12. Их дээд сургуулийн түвшний сурхай бичиг, гарын авлага бичиж хэвлүүлсэн байх;

7.7.13. Судалгааны семинар тогтмол удирдан явуулдаг байх.

<sup>2</sup>Нийгэм, хумүүнлэгийн салбарын Scopus-д бүртгэлтэй сэтгүүлд хэвлэсэн бүтээлийг тооцож болох ба Web of Science IF-JCR-д хэвлүүлсэн бүтээлтэй профессор шаардлагыг түрүүлж биелүүлсэнд тооцогдоно. Scopus-д бүртгэлтэй CiteScore үнэлгээ бүхий сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийг энд тооцно.

7.8. Профессор болон дэд профессорын зэрэглэлд ажиллах багшийг шалгаруулахдаа ерөнхий болон тусгай шаардлагаас гадна сүүлийн 5 жилд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлыг нь гол шалгуур болгон Хавсралт 1-д (Хүснэгт 2) заасан үзүүлэлтүүдийг ашиглан нэр дэвшигчдийг сонгон шалгаруулна. Профессорын зэрэглэлд нэр дэвшигч нь сүүлийн 5 жилд 2-оос цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн<sup>2</sup> (үүний 1-ээс доошгүйг 1-р юмуу холбоо барих зохиогчоор) эсвэл өөрийн судалгааны ажлын үр дүнг агуулсан монограф бүтээл бичиж хэвлүүлсэн байх шаардлагатай. SPI Expedited-ийн дундаж, түүнээс дээгүүр индекстэй академик пресст хэвлүүлсэн монографийг энд тооцно.

7.9. Ахлах багшийн зэрэглэлд 1 жилээс доошгүй хугацаагаар ажилласан багшид дэд профессорын зэрэглэлд өрсөлдөх эрх нээгдэнэ. Дэд профессорын зэрэглэлд өрсөлдөөд болзол хангагүй бол ахлах багшийн зэрэглэлд дахин 3 жилийн хугацаагаар тасралтгүй ажилласны дараа дэд профессорын зэрэглэлд өрсөлдөж болно.

7.10.Дэд профессорын зэрэглэлд 3 жилийн хугацаагаар тасралтгүй ажилласан багшид профессорын зэрэглэлд өрсөлдөх эрх нээгдэнэ. Профессорын зэрэглэлд өрсөлдөөд болзол хангагүй бол дэд профессорын зэрэглэлд дахин 3 жилийн хугацаагаар тасралтгүй ажилласны дараа профессорын зэрэглэлд өрсөлдөж болно<sup>3</sup>.

#### **Найм Багшийн орон тоог тогтоох**

8.1. МУИС-ийн багшийн орон тоог сургалтын хөтөлбөр дэх багц цагийн хэмжээ ба суралцагчийн тоотой уялдуулан хичээлийн жил бүр шинэчлэн тогтоож, МУИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж тушаалаар баталгаажуулна.

8.2. МУИС-ийн багшийн орон тоог тогтоохдоо, сургалтын хөтөлбөрийг биелүүлэхэд шаардлагатай нийт багц цагийн 80-аас доошгүй хувийг үндсэн буюу бүтэн орон тоогоор ажилладаг багш нараар гүйцэтгүүлэхээр тооцно.

8.3. Тухайн мэргэжлийн салбарт ажиллаж байгаа эрдмийн зэрэгтэй багш нарын тоонд нийт профессорын боломжит орон тоог харгалзуулж, түүний дотор профессор, дэд профессорын зэрэглэлийн харьцаа 1:3-аас хэтрэхгүй байна. МУИС-ийн профессор цол хүртсэн багш нарыг энэхүү харьцаанд оруулж тооцохгүй.

8.4. Энэхүү харьцааг бүрэлдэхүүн/салбар сургууль бүрд үндсэн орон тоогоор ажиллаж байгаа эрдмийн зэрэгтэй багшийн тоогоор тогтоох бөгөөд шинжлэх ухааны тодорхой нэг чиглэлээр эрдмийн зэрэгтэй 4-өөс доошгүй багш байгаа нөхцөлд нэг нь профессор байх боломж бүрдэнэ. Шинжлэх ухааны чиглэл хооронд профессорын орон тоог шилжүүлэхгүй.

8.5. Цагийн, гэрээт, зөвлөх болон зочин багш нар дэд профессор, профессорын зэрэглэлд нэр дэвшихгүй.

<sup>3</sup> Болзол хангасан ч орон тоо байхгүй улмаас профессорын зэрэглэлд ажиллаагүй тохиолдолд энэ заалт хамаарахгүй.

8.6. Гадаад дотоодын эх сурвалжийн тогтмол тэтгэлэг, санхүүжилтээр судалгаа, сургалтын тодорхой чиглэлийг хөгжүүлэх зорилгоор тухайн байгууллага, хувь хүний нэрэмжит профессорын орон тоог тодорхой хугацаагаар бий болгохыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн Эрдмийн зөвлөл дэмжсэн тохиолдолд захирлын тушаалаар шийдвэрлэж, санхүүжилтийн хугацаанд ажиллуулна.

#### Ес. Багш нарын хичээлийн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ

1117144746  
УХД0072 9104399

9.1. МУИС-ийн багш нь дараах үндсэн гурван төрлийн ажлыг гүйцэтгэх үүрэгтэй. Үүнд:

- А. Сургалт;
- Б. Эрдэм шинжилгээ;
- В. Бусад ажил (сургууль, нийгэм, олон нийтэд хандсан үйл ажиллагаа).

9.2. Багшийн хөдөлмөрийг багшийн багц цаг (ББц)-аар үнэлэх ба дээрх ажлын нийт хэмжээ хичээлийн жилд 26 ББц байна.

9.3. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч багш нарынхаа шинэ хичээлийн жилийн ноогдлыг өмнөх хичээлийн жилийн төгсгөлд тооцож, сургалт хариуцсан нэгжийн удирдлагад ирүүлнэ.

9.4. Албан тушаалын зэрэглэлээс хамаарч хичээлийн жилд багшийн гүйцэтгэх сургалт, эрдэм шинжилгээ болон бусад ажил дараах багц цагийн хэмжээтэй байна. Үүнд:

Албан тушаалын зэрэглэл	Сургалт "A"	Эрдэм шинжилгээ "B"	Бусад ажил "B"
Профессор	12	10	4
Дэд профессор	13	8	5
Ахлах багш	15	6	5
Багш	16	5	5
Дадлагажигч багш	13	4	7

Тайлбар: Биөийн тамирын тэнхим, Гадаад хэлний төвийн докторын зэрэггүй багш нар нэг хичээлийн жилд сургалтын 18 багц цагийг биелүүлнэ. Энэ нөхцөлд эрдэм шинжилгээний багц цагийг сургалтын багц цаг руу шилжүүлэн хорогдуулж гүйцэтгүүлнэ.

Багш нар хичээлийн жилийн эхэнд тэнхим/хөтөлбөрийн багш нарын цагийн ачаалал, ажлын шаардлага зэргийг харгалзан А ба Б цагийн ачааллыг 30 хүртэл хувиар нэгээс нөгөөд шилжүүлэн тооцоohoор хөдөлмөрийн гэрээнд тусган ажиллаж болно. Б-ээс А руу зөвхөн Б1.1-ийг шилжүүлэн тооцоохыг зөвшөөрнө.

9.5. Аль ч зэрэглэлийн багшийн хувьд МУИС-д судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж цалингийнхаа тодорхой хувийг төслөөсөө санхүүжүүлж байгаа нөхцөлд түүнтэй дүйцүүлэн А цагийн ноогдоо хорогдуулан тооцуулж болно. Энэ тохиолдолд тухайн зэрэглэлдээ бүтэн ажилласан гэж үзнэ. Цалингийн гаднын эх

үүсвэр нь дуусгавар болсон тохиолдолд тухайн багшийг өмнө ажиллаж байсан зэрэглэл дээр нь үргэлжлүүлэн ажиллуулна.

9.6. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, дэд захирал хичээлийн жилд профессорын зэрэглэлийн сургалтын 25% хүртэлх ачаалалд оногдох хичээлийг цагаар зааж болох ба хэтрүүлэхийг хориглоно. Тэнхимийн эрхлэгчийн хичээлийн жилд гүйцэтгэх сургалтын цагийн ноогдлыг 20%-иар хөнгөлнө. Тэнхимийн эрхлэгчийг сургалтын үйл ажиллагааны багц цагийн ноогдлыг хэтрүүлэхийг дэмжихгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд заасан илүү цагийн 1117144746 хөлсийг энэ журмын УХД00729104399 13.6-13.10 дугаар заалтуудыг баримтлан бодож олгоно.

#### Арав. Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийг тооцох

10.1. Сургалтын үйл ажиллагааны 48 цагийг 1 ББц гэж тооцно.

10.2. Сургалтын үйл ажиллагаа нь сургалтанд бэлтгэх, танхимын сургалт, зөвлөгөө өгөх болон суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэх гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд дараах багцыг 1 ББц гэж ойлгоно.

№	Сургалтын хэлбэр	Сургалтанд бэлтгэх	Танхимын сургалт	Суралцагч -дад зөвлөгөө өгөх	Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх	Нийт Цаг
1	Лекц	12 цаг	16 цаг	6 цаг	14 цаг	48 цаг
2	Семинар, лаборатории	8 цаг	32 цаг	4 цаг	4 цаг	48 цаг

10.2.1. Сургалтад бэлтгэх: Сургалтын хөтөлбөр, хичээлийн тодорхойлолт боловсруулах, сургалтын материал, цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, тест, шалгалтын сэдэв боловсруулах.

10.2.2. Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх: Танхимын сургалтаас бусад цагаар явцын болон улирлын шалгалт, бусад хэлбэрээр суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэх (реферат, гэрийн уншлага, бие даалт шалгах зэрэг нь шалгалтын хэлбэрүүд гэж үзнэ; тэнхим, сургалтын албаны саналыг үндэслэн тухайн салбарын магистрант, докторантыг оюутны мэдлэг, чадварыг үнэлэх үйл ажиллагаанд оролцуулж болно).

10.2.3. Нэмэлт цаг тооцох: Сургалтын хөтөлбөрт шинээр тусгагдсан хичээлийг анх удаа заасан багшийн сургалтад бэлтгэх цагийг тэнхимийн саналыг үндэслэн 30% хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцож болно. Гэхдээ уг хичээлийн тодорхойлолт иж бүрэн хийгдсэн эсэхийг сургалт хариуцсан нэгж, тэнхим хамtran баримтжуулна. Суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн (цахим, мэдээллийн технологи, загварчлах (симуляци), асуудал шийдвэрлүүлэх, тухайлсан судалгаа г.м.), англи хэлээр хичээл заах, сургалтын шинэлэг арга барилаар заасан хичээлд бэлтгэхэд тооцох багц цагийг 50% хүртэл нэмэгдүүлж болох бөгөөд тэнхимийн саналыг үндэслэн сургалт хариуцсан нэгж шийдвэрлэнэ. Гурван багц цагийн багтаамжтай хичээлийн

хэрэглэгдэхүүн, гарын авлага боловсруулах, лабораторийн ажлыг шинээр тавих, семинар, дадлагын ажил, гадаад хэлний хичээлээр тараах материал бэлтгэх, хичээлийн иж бүрэн үзүүлэн болон Е-сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх зэрэг ажилд тооцох багц цагийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн сургалт хариуцсан нэгж тогтоно.

10.3. *Лекцийн хичээл*. Бакалаврын сургалтын бүх ангиллын хичээл болон магистр, докторын сургалтын ерөнхий суурь хичээлийн лекцийн хичээлд суралцагчдын тоог харгалзан үржүүлэх коэффициент хэрэглэн доорх байдлаар багц цаг тооцно. Үүнд:

Суралцагчийн тоо	10-50	51-100	101-160
Үржүүлэх коэффициент	1	1.2	1.4

Жич: *Лекцийг 160-аас ихгүй суралцагчдад уншихыг зохижтой гэж үзэх бөгөөд тусгай тонооглогдсон лекцийн танхимд түүнээс олон суралцагчдад лекц уншихыг зөвшөөрөх боловч үржүүлэх коэффициент тогтмол 1.4 байна.*

*Суралцагчийн тоо 10 хүрээгүй тохиолдолд ноогдох багц цагийн хэмжээг улирлын эхэнд бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хуралдааны саналыг үндэслэн сургалт эрхэлсэн дэд захирал шийдвэрлэнэ.*

Магистр, докторын сургалтын мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн лекц уншсан багшийн багц цагийг доорх байдлаар тооцно. Үүнд:

Суралцагчийн тоо	3-10	11-30	31≤
Үржүүлэх коэффициент	1	1.1	1.2

Жич: *Суралцагчийн тоо 3 хүрээгүй тохиолдолд ноогдох багц цагийн хэмжээг улирлын эхэнд бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хуралдааны саналыг үндэслэн Сургалт эрхэлсэн дэд захирал шийдвэрлэнэ.*

10.4. *Семинар, дадлагын хичээл*: Магистр, докторын сургалтын ерөнхий суурь хичээл болон бакалаврын сургалтын хичээлийн семинарын бүлгийг дунджаар 25 буюу 20-30 суралцагчаар, Биеийн тамирын хичээлийн бүлгийг 40 суралцагчаар тус тус зохион байгуулна. Лабораторийн хичээлийн бүлэгт хамрагдах суралцагчийн тоог лабораторийн багтаамж, хүчин чадлыг бүрэн ашиглахуйц хэмжээгээр тогтоно. Байгалийн ухааны болон компьютер, лингафоны лабораториудыг чөлөөт цагийн хуваарыг шилжүүлж ажиллуулахыг зөвшөөрнө.

10.5. *Хээрийн, мэргэжих/үйлдвэрлэлийн, танилцах болон багшлах дадлага*: Хээрийн болон багшлах дадлагад 8 суралцагчийг 2 долоо хоног удирдсан багшид сургалтын 1 ББц, үйлдвэрлэлийн дадлага удирдахад мөн хугацаанд 15 суралцагчид 0.5 ББц, мэргэжлийн магистрын мэргэжих дадлага удирдахад мөн хугацаанд 10 суралцагчид 0.5 ББц, танилцах дадлага удирдсан болон багшлах дадлага удирдсан боловсрол, сэтгэл судлалын багш нарын хувьд мөн хугацаанд 30 суралцагчид 0.5 ББц тооцно.

### B1. Багц цагаар үл хэмжигдэх сургалтын үйл ажиллагаа

Тодорхой хичээлийн багц цагийн үнэлгээнд оруулах боломжгүй үйл ажиллагааг цагаар тооцож хөлс олгоно. Нэг цагийн үнэлгээг тогтоох болон элсэлт, гадаад хэлний нэгдсэн шалгалтын комисст ажлын хөлс олгохыг МУИС-ийн захирлын тушаалаар, доор заагдсан бусад төрлийн ажилд хөлс олгохыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

10.6. Комиссын бүрэлдэхүүнтэй шалгалт авах. Хөндлөнгийн<sup>104</sup> батлах, элсэлтийн, гадаад болон монгол хэлний нэгдсэн шалгалт авах болон суралцагчийн судалгааны ажил хамгаалуулах комиссын гишүүдэд зохих тушаалаар хөлс олгох цагийг дараах жишгээр тооцно. Үүнд:

Шалгалтын төрөл	Бүлгийн хэмжээ	Тооцох цаг
Бакалаврын сургалтын хөндлөнгийн болон батлах шалгалт авсан комиссын гишүүд	30 хүнтэй бүлэгт 30-аас дээш хүн бүрт	3.0 0.1
Магистр, докторын элсэлтийн шалгалт авсан комиссын гишүүд	5 хүртэл хүнтэй бүлэгт 5-аас дээш хүн бүрт	2.0 0.4
Магистр, докторын гадаад болон монгол хэлний нэгдсэн шалгалт бичгээр авсан комиссын гишүүд	30 хүнтэй бүлэгт 30-60 хүнтэй бүлэгт 60-аас дээш хүнтэй бүлэгт	3.0 4.0 5.0
Тестийн шалгалтын сэдэв боловсруулах	2 хувилбартай нэг шалгалтын тест	4.0

### 10.7. Бакалаврын төгсөлттэй холбоотой ажлууд:

Бакалаврын ажил хамгаалуулах комиссын нарийн бичгийн дарга	10 хүртэл хүнтэй бүлэгт 10-аас дээш хүн бүрт	2.5 0.4
Бакалаврын ажил хамгаалуулах комиссын дарга, гишүүн	10 хүртэл хүнтэй бүлэгт 10-аас дээш хүн бүрт	2.0 0.3
Бакалаврын ажил удирдсан багш	1 ажил	20.0
Бакалаврын ажилд шүүмж бичсэн багш	1 ажил	3.0

### 10.8. Магистрын төгсөлттэй холбоотой ажлууд:

Магистрын урьдчилсан хамгаалалтын 3-7 гишүүнтэй комиссын дарга, гишүүд	5 хүртэл хүнтэй бүлэгт 5-аас дээш хүн бүрт	2.0 0.3
Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга	5 хүртэл хүнтэй бүлэгт 5-аас дээш хүн бүрт	2.5 0.4
Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд	5 хүртэл хүнтэй бүлэгт 5-аас дээш хүн бүрт	2.0 0.4
Магистрын ажлын шүүмж бичсэн багш	1 ажил	6.0
Магистрын ажил удирдсан багш	1 ажил	48.0
Мэргэжлийн магистрын дадлага хамгаалуулах комиссын гишүүн	10 хүртэл хүнтэй бүлэгт 10-аас дээш хүн бүрт	2.0 0.2

10.9 Докторын төгсөлттэй холбоотой ажлууд:

Докторын ажил урьдчилсан хамгаалуулах комиссын дарга, гишүүд (10-15 хүн)	1 докторант	2.0
Докторын ажил хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга	1 докторант	5.0
Докторын ажил хамгаалуулах зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд	1 докторант	1117144746 УХ3072 9104399
Докторын ажил удирдсан багш	1 докторант	72.0
Докторын ажлын шуумж бичсэн багш	1 докторант	9.0
Докторын ажлын зөвлөхөөр ажилласан багш	1 докторант	8.0

**Арван нэг. Эрдэм шинжилгээ, зохион бүтээх болон бусад бүтээлч үйл ажиллагаа**

11.1. Б1. Эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх<sup>4</sup>

1	Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий мэргэжлийн сэтгүүл: - Тухайн судалгааны салбарын дундаж индекстэй тэнцүү болон түүнээс дээгүүр индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл - Дунджаас доогуур индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	1 өгүүлэл	10.0 ББц
2	Web of science -д бүртгэлгүй боловч мэргэжлийн түвшинд хянаагддаг (peer-review) гадаад хэл дээр хэвлэгддэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	1 өгүүлэл	4.0 ББц
3	МУИС-д бүртгэлтэй сэтгүүлийн жагсаалтад орсон, англи хэлээр хэвлэгддэг, олон улсын редакцын зөвлөл бүхий дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл МУИС- д бүртгэлтэй сэтгүүлийн жагсаалтад орсон, монгол, англи хэлээр холимог хэлбэрээр болон монгол хэлээр хэвлэгддэг, мэргэжлийн түвшинд хянаагддаг дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	1 өгүүлэл	3.0 ББц
		1 өгүүлэл	2.0 ББц

\*Web of science-ийн үнэлгээний системтэй ижил төстэй, мэргэжлийн өндөр түвшинд хянаагддаг бусад үнэлгээний системүүдийг/Scopus г.м/дээрх ангилалд дүйцүүлэн тооцох боломжтой бөгөөд энэ талаар МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгжээс дүгнэлт гаргаж, МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хичээлийн жилийн эхэнд хэлэлцүүлэн батлуулна. Бусад дотоодод хэвлэгддэг эрдэм

<sup>4</sup>Сургуулийн эрдмийн зөвлөл тухайн салбарын сэтгүүлүүдийн дундаж индексийг хичээлийн жилийн эхэнд Web of science-ийн үнэлгээнд үндэслэн тогтооно. Мэн мэргэжлийн түвшинд хянаагддаг /peer-review/ болон хянаагддаггүй сэтгүүлийн жагсаалтыг гаргана. Хамтын бүтээлд багц цагийг тухайн бүтээлд зохиогчийн оруулсан хувь нэмрээс хамааруулан 1-р зохиогчид бүтнээр, харилцагч зохиогчид 0.8-аар үржүүлж, бусад зохиогчид 0.5-аар үржүүлж тооцно. Өгүүлэл нь хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) тохиолдолд багц цаг тооцож болно. Өгүүллийг зохиогчийн зөвшөөрснөөр дараачийн хичээлийн жилийн ажлын үнэлгээнд нь тооцож болох бөгөөд бусад тохиолдолд өмнөх онуудад хэвлүүлсэн бүтээлийг үнэлгээнд тооцожгүй.

шинжилгээний сэтгүүлүүдийн ангиллын жагсаалтыг мөн адил дээрх нэгжээс гаргаж, МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн батална.

### 11.2. Б2. Эрдэм шинжилгээний хуралд оролцох<sup>5</sup>

1	Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий мэргэжлийн сэтгүүлийн тусгай дугаар гаргадаг олон улсын мэргэжлийн нийгэмлэгийн хурал: Уригdsan илтгэл Аман илтгэл Үзүүлэн илтгэл	1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл	1117144746 УХД0072 9104399 4.0 ББц 3.0 ББц 2.0 ББц
2	Олон улсын хурал <sup>6</sup> : Уригdsan илтгэл Аман илтгэл Үзүүлэн илтгэл	1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл	3.0 ББц 2.0 ББц 1.5 ББц
3	Улсын хэмжээнд <sup>7</sup> : Уригdsan илтгэл Аман илтгэл Үзүүлэн илтгэл	1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл	1.8 ББц 1.5 ББц 1.0 ББц
4	Сургуулийн хэмжээнд: Аман илтгэл Үзүүлэн илтгэл	1 илтгэл 1 илтгэл	1.0 ББц 0.8 ББц

### Б3. Эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх

1	Монограф <sup>8</sup> /нэг сэдэвт бүтээл/ - Гадаад хэлээр	1 х.х 1 х.х	0.8 ББц 1.0 ББц
2	Докторын диссертаци /хамгаалсан/	1 ажил	4.0 ББц
3	Сурах бичиг <sup>9</sup> - Гадаад хэлээр Орчуулгын бүтээл Гарын авлага	1 х.х 1 х.х 1 х.х 1 х.х	0.8 ББц 1.0 ББц 0.5 ББц 0.2 ББц

### 11.3. Б4. Оюуны өмчийн бүтээл

1	Шинэ бүтээлийн патент/гадаадад (зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан) Шинэ бүтээлийн патент/дотоодод (зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан)	1 бүтээл 1 бүтээл	8.0 ББц 3.0 ББц
2	Бүтээгдэхүүний загвар/гадаадад (зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан) Бүтээгдэхүүний загвар/дотоодод	1 бүтээл	3.0 ББц

<sup>5</sup>Хурлын багц цагийг үндсэн илтгэгчдэд бүтнээр, бусад хурлын илтгэлд оролцогчдод тэнцүү хувааж тооцно.

<sup>6</sup>5-аас доошагүй улсын судлаачид оролцсон эрдэм шинжилгээний хурлыг олон улсын хурал хэмээн тооцно.

<sup>7</sup>Хуралд оролцож буй байгууллагын тоо 3-аас олон бол улсын хэмжээний хурал хэмээн тооцно.

<sup>8</sup>Гадаад хэлээрх монографыг олон улсын хэвлэлийн индексээр (SPI) тодорхойлох ба тодорхойлох боломжгүй (эсвэл монгол хэл дээр бичигдсэн) тохиолдолд хэвлэлийн газар, редакцийн түвшин, хэвлэгдсэн тоо зэрэгт үндэслэсэн мэргэжлийн эрдэмтэд шинжэчдийн дүгнэлтээр бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөл тодорхойлно. Үнэлгээг МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгж зохион байгуулна. Олон зохиогчтой тохиолдолд зохиогчийн оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, тодорхойгүй тохиолдолд багц цагийг бүх оролцогчдод тэнцүү хувааж тооцно. Бусдын монографд булэг бичсэн тохиолдолд харгалзах хэвлэлийн хуудсаар тооцогдох багц цагийн хэмжээг 0.5-аар үржүүлж тооцно.

<sup>9</sup>Сурах бичиг, орчуулгын бүтээл, гарын авлага нь сургуулийн эрдмийн зөвлөлөөр зөвшөөрөгдсэн байх ба олон зохиогчтой тохиолдолд зохиогчдын оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, хэрэв зохиогчдын оролцоо тодорхойгүй бол багц цагийг бүх оролцогчдод тэнцүү хуваана. Сурах бичигийг дахин хэвлүүлсэн тохиолдолд зөвхөн нэмэгдсэн агуулгад харгалзах хэвлэлийн хуудастаа ноогдох багц цагийг тооцно.

	(зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан)	1 бүтээл	1.0 ББц
3	Зохиогчийн эрхээр баталгаажуулсан бүтээл <sup>10</sup>	1 бүтээл	0.3 ББц

11.4. Б5. Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлын үнэлгээ<sup>11</sup>

1	ШУТС-ийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл Удирдсан Гүйцэтгэсэн	1 ажил 1 ажил	1117144746 УХДО021399 1.0 ББц 0.8 ББц
2	Төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгж, Монгол дахь олон улсын байгууллагын гэрээт, захиалгат болон МУИС-аас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил Удирдсан Гүйцэтгэсэн	1 ажил 1 ажил	1.0 ББц 0.8 ББц
3	Гадаадтай хамтарсан төсөл Удирдсан Гүйцэтгэсэн Гадаадтай хамтарсан хөтөлбөр Удирдсан Гүйцэтгэсэн	1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил	1.5 ББц 1.0 ББц 2.0 ББц 1.5 ББц

11.5. Б6. Эрдэм шинжилгээний бусад ажил

1	Эрдэм шинжилгээний их семинарт илтгэл тавих	1 илтгэл	0.5 ББц
2	Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүн Дотоодын сэтгүүл Гадаадын сэтгүүл	1 хич.жил 1 хич.жил	0.5 ББц 1.0 ББц
3	Салбар/профессорын мэргэжлийн семинар (12 удаа) Удирдах Илтгэл тавих	1 хич.жил 1 удаа	0.5 ББц 0.2 ББц
4	Эрдэм шинжилгээний бүтээл редакторлах Мэргэжлийн сурх бичиг Монограф Орчуулгын бүтээл	1 х.х 1 х.х 1 х.х	0.2 ББц 0.2 ББц 0.3 ББц
5	Хууль, үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан	1 баримт бичиг	1.5 ББц

<sup>10</sup>Зохиогчийн эрхийн бүтээлд программ хангамжийг тооцино.

<sup>11</sup>Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажил нь МУИС-ийн дансаар шилжин орж зарцуулагдсан эсхүл төсөл, гэрээт ажлын шимтгэл төлөгдсөн, хөрөнгө оруулалт хийгдсэн тохиолдолд багц цагт үнэлзэгдэнэ. Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж МУИС-д мөнөэн болон материаллаг орлого оруулсан тохиолдолд орлогын дунг дараах томьёог ашиглан ББц-д шилжүүлэн тооцож болно:

$$\text{ББц} = \frac{M_1 + M_2 + M_3}{B_k}$$

Үүнд:  $M_1$ -мөнгөн орлогын дун (хандив, эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлын шимтгэл);  $M_2$ -материаллаг орлогын дун (судалгааны багаж тоног төхөөрөмж г.м хөрөнгө оруулалтын үнийн дунгийн 10%-р тооцино);  $M_3$ -судалгааны ажлыг нь удирдаж буй суралцаагчдын сургалтын төлбөрийг тэлсэн дун;  $B_k$ -багшийн нэг багц цагийн үнэлгээ /тухайн албан тушаалын үндсэн цалинейн жилийн дунг 26-д хувааж тооцоно/. Олон багц оролцсон төслийн хувьд төслийн удирдагч ба гишүүдийн оролцоог харгалзан багц цагийг хувааж тооцино. Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж МУИС-д оруулсан мөнгөн болон материаллаг орлогоо багц цагт тооцуулахгүй тохиолдолд түүнд урамшуулалт олгох асуудлыг МУИС-ийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

6	Боловсруулж батлуулсан стандарт /MNS/ <sup>12</sup>	1 стандарт	1.0 ББц
7	Гадаадын мэргэжлийн сэтгүүлийн өгүүлэлд шүүмж бичих	1 өгүүлэл	0.5 ББц
8	Суралцагчдыг удирдаж эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавиулах (давхардуулж тооцохгүй): Олон улсад 1-3 дугаар байр Сургууль/улсад 1-3 дугаар байр Бүрэлдэхүүн/салбар сургуульд 1-3 дугаар байр Илтгэл тавиулбал	1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл	1.0 ББц 0.5 ББц 0.3 ББц 0.1 ББц

Жич: Багшийн ажлыг тооцох дээрх үзүүлэлтэд тусгагдаагүй эрдэм шинжилгээний бусад ажлыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн онол, практикийн ач холбогдол, хөдөлмөр зарцуулалтыг харгалзан 1 ББц-аас дээшгүй хэмжээгээр үнэлэн багц цаг оноож болно.

### Арван хоёр. Бусад ажил

#### B. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ

12.1. Сургуулийн удирдлага, зохион байгуулалт, суралцагчдын төлөвшил, соёл, олон нийтийн ажил, нийгэмд үйлчлэх чиглэлээр багшийн хийсэн дараах ажлуудад харгалзах багц цаг тооцно.

1	Лаборатори, кабинет хариуцан ажиллах	1 хич. жил	1.0 ББц
2	Тэнхимийн даалгавраар багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх эсвэл хичээлд сууж дагалдан суралцах	2 цаг	0.5 ББц
3	Сургуулийн захиргааны шийдвэрээр <sup>13</sup> Сургалт, заах арга, сургалтын технологийг боловсронгуй болгох, заавар, дүрэм, бусад баримт бичиг боловсруулах зэрэг үүрэгт ажилд оролцох Тэнхимийн хурлын шийдвэрээр тэнхимийн ажил гүйцэтгэх	1 удаа	Тушаалаар нэг ажилд 1 ББц-аас ихгүй 0.5 ББц-аас ихгүй
4	Олимпиад уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах Олон улсын хэмжээнд Улсын хэмжээнд Сургуулийн хэмжээнд Бүрэлдэхүүн/салбар сургуулийн хэмжээнд	1 арга хэмжээ	2.0 ББц 1.5 ББц 1.0 ББц 0.5 ББц
5	Суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажил:	1 хич. жил	1.0 ББц

<sup>12</sup>Боловсруулж батлуулсан стандарт нь нэгээс олон зохиогчтой бол багц цагийг бүх оролцогчдод тэнцүү хуваана.

<sup>13</sup>Тушаалаар тухайн үүрэгт ажлын хэлс олгогдсон тохиолдолд багц цаг давхардуулж тооцохгүй.

	Зөвлөх багш Соёл, олон нийтийн ажил зохион байгуулах	1 арга хэмжээ	0.5 ББц
6	Эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	1.0 ББц
7	Олон улсын хурал, семинар зохион байгуулах	1 хурал	2.0 ББц 1117144746
8	Улсын хэмжээний хурал зохион байгуулах	1 хурал	1.0 ББц УД00000004399
9	Нийгэм, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа Телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх Өдөр тутмын сонин хэвлэлд өгүүлэл, нийтлэл бичих Үндэсний зөвлөхөөр ажиллах	1 нэвтрүүлэг 1 нийтлэл 1 удаа	0.2 ББц 0.5 ББц 1.0 ББц
10	МУИС-ийн болон бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн (давхардуулж тооцож болно)	1 хич. жил	1.0 ББц
11	Мэргэжлийн холбоодыг удирдан зохион байгуулах, тэргүүлж ажиллах	1 хич. жил	1.0 ББц
12	Тэнхимийн эрхлэгчийн зөвшөөрлөөр суралцагчдад зориулсан дугуйлан, клуб ажиллуулах	1 хич. жил	1.0 ББц

### Арван гурав Багшийн цагийн ноогдлыг төлөвлөх, гүйцэтгэлийг дүгнэх, хянах<sup>14</sup>

13.1. Дараагийн хичээлийн жилд гүйцэтгэх нийт сургалтын ажлын цагийг сургалт хариуцсан нэгжээс ирүүлсэн хичээл тандалтын дүгнэлтийг үндэслэн тухайн оны 05-р сард тэнхимийн эрхлэгч тооцож гаргана. Багш нарын сургалтын цагийг жигд хуваарилсан байх шаардлагатай бөгөөд багш хүрэлцэхгүй, байхгүй нөхцөлд тухайн багшаар ноогдлын нь 40% хүртэл илүү цаг заалгах, эсвэл цагийн багш ажиллуулна. Мөн хичээлийн жилийн явцад өвчилсөн, ажлаас өөрчлөгдсөн, гадаад, дотоодод томилолтоор ажилласан багшийн хичээлийг тэнхимийн эрхлэгчийн зөвшөөрлөөр өөр багшид шилжүүлэн, илүү цаг гүйцэтгүүлж болно. Онцгой тохиолдолд ноогдлын 40%-аас хэтэрсэн илүү цаг заалгах шаардлага гарвал бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ. Дадлагажигч багшаар илүү цаг заалгахгүй.

13.2. Хичээлийг мэргэжлийн тэнхим хариуцах бөгөөд тэнхимийн эрхлэгч нь багш нарынхаа өөрийн сургууль болон бусад бүрэлдэхүүний сургуульд заах хичээлийн ноогдлыг зохицуулна. Сургалт хариуцсан нэгжийн удирдлага бусад сургуулийн багштай шууд тохирон хичээл заалгах, цагийн багшийн журмаар ажиллуулахыг хориглоно. Сургууль хоорондын тооцоог суралцагчийн багц цагт

<sup>14</sup>Тооцоог нэгдсэн аргачлалаар хийх программыг мэдээллийн системд байршуулж, бүрэлдэхүүн/салбар сургуулиуд шууд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

үндэслэн хийх бөгөөд тухайн хичээлийн жилийн нийт багц цагийн тооцоог сургалт хариуцсан нэгж нэгтгэн хянаж, санхүү хариуцсан нэгжид хүргүүлнэ.

13.3. Хичээлийн жилийн төгсгөлд багш нарын сургалтын ажлын гүйцэтгэлийг тэнхимийн эрхлэгч тооцож сургалт хариуцсан нэгжийн удирдлага хянана. Эрдэм шинжилгээний, мэргэжлийн үйлчилгээний ажлыг тэнхимийн эрхлэгч, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргатай хамтран үнэлнэ. Багш нарын жилийн нийт (А,Б,В) ажлын гүйцэтгэлийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал хянаж, баталгаажуулна.

13.4. Багш нарын ажлын гүйцэтгэлийн дүнг сургалт хариуцсан нэгжийн удирдлага хянаж, нэгдсэн дүнг захиргаа, хүний нөөц хариуцсан нэгжид хүргүүлнэ. Захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж нь багш нарын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд мониторинг хийж, үр дүнг МУИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж ээлжийн амралт олгоно.

13.5. Багш хичээлийн жилд энэ журмын 9.4-т заасан сургалт (А), эрдэм шинжилгээ (Б), бусад ажил (В)-ын норм тус бүрийг заавал биелүүлэх үүрэгтэй.

13.6. А, Б-ийн аль нэг дутвал илүү хэсгээс 1.5 ББц-ийг дутуу хэсгийн 1 ББц-тай дүйцүүлэн шилжүүлэн тооцно. В хэсгийн гүйцэтгэл дутвал А ба Б-ээс 1 ББц-ийг В-ийн 2 ББц-тай дүйцүүлэн шилжүүлэн тооцох ба харин В-ийн илүү гүйцэтгэлээс А, Б-д шилжүүлэн тооцохгүй.

13.7. Багш тухайн хичээлийн жилийн эхэнд хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа эрдэм шинжилгээний ажлын ноогдоо сургалтын ажлаар, эсвэл сургалтын ноогдоо эрдэм шинжилгээний ажлаар (энэ журмын 9.4 дугаар заалтыг үндэслэн) нөхөхөөр тусгаж болох ба гэрээнд заагаагүй нөхцөлд цаг шилжүүлэн тооцох бол энэ журмын 13.6 дугаар заалтыг баримтална. Ерөнхий суурь хичээл заадаг үндсэн багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор хөдөлмөрийн гэрээнд тусгасны үндсэн дээр эрдэм шинжилгээний ажлын ноогдлыг сургалтын үйл ажиллагаагаар шилжүүлэн гүйцэтгэж болно.

13.8. Илүү цагийн хөлс, урамшуулалт олгох нөхцөл:

13.8.1. А, Б, В хэсгийн норм тус тусдаа биелэгдсэн нөхцөлд А-д илүү цагийн хөлс олгоно. Гэхдээ Б-ээс А-д цаг шилжүүлэн илүү цаг гаргахыг зөвшөөрөхгүй ба түүнд хөлс олгохгүй.

13.8.2. А, Б, В тус тусдаа биелсэн болон Б-ийн нормыг Б1.1-ээр бүрэн биелүүлсэн тохиолдолд Б1.1-ийн нормоос давсан гүйцэтгэлд илүү цагийн хөлс олгох ба Б-ийн нормын 30% хүртэл илүү цаг тооцно.

13.9. Багшийн сургалтын ажлын (А) нормоос давуулан гүйцэтгэсэн илүү ББц-ийн хөлсийг дараах аргачлалаар бодно. Үүнд:

13.9.1. Нормын 40% хүртэлх багц цагийн хөлсийг “үндсэн үнэлгээ”-гээр бодож олгоно. Нэг багц цагийн “үндсэн үнэлгээ”-г албан тушаалын багш зэрэглэлийн дунд шатлалын үндсэн цалингийн гуравны нэгээр тооцно. Зөвлөх багш нарын илүү цагийн “үндсэн үнэлгээ” үндсэн багшийн үнэлгээтэй адилаар тооцно.

13.9.2. Сургуулийн захиргааны зөвлөлийн шийдвэрээр нормын 40%-иас илүү багц цагт хөлс олгохоор тогтоон нөхцөлд түүний нэг багц цагийн хөлсийг “үндсэн үнэлгээний” 75%-иар тогтооно.

13.10. Багшийн эрдэм шинжилгээний ажлын (Б) нормоос давуулан гүйцэтгэсэн (журмын 13.8.2 дахь заалтыг үндэслэн) илүү нэг ББЦ-ийн хөлсийг бодохдоо багшийн тухайн албан тушаалын үндсэн цалингийн гуравны нэгээр тооцно.

13.11. Хичээлийн жилийн эцэст багш нарын ажлын гүйцэтгэлийг дүгнэж, бүрэн биелсэн нөхцөлд ээлжийн амралт олгоно. Багшийн ажлын А, Б, В хэсгийн аль нэгийг дутуу биелүүлсэн тохиолдолд дутсан багц цагт ноогдох цалинг буцаан төлүүлэх буюу ээлжийн амралтын олговоос суутгана. Бүрэлдэхүүн/салбар сургууль нь багш нарынхаа жилийн цагийн гүйцэтгэлийг урьдчилан тооцож, боломжтой гэж үзвэл эхний улирлын эцэст гүйцэтгэсэн илүү цагийн хөлсний тодорхой хэсгийг олгож болно.

13.12. Багш нарын бусад бүрэлдэхүүн/салбар сургуульд заасан хичээлийн цагийн тооцоо сургууль хоорондын тооцоогоор хийгдэх тул цагийн багшийн журмаар ажиллуулахыг хориглоно. Тухайн багш үндсэн цагийн ноогдоо давуулан биелүүлсэн нөхцөлд илүү цаг олгох асуудлыг харьяалах сургууль нь шийдвэрлэнэ.

#### **Арван дөрөв. Багшийг албан тушаалын зэрэглэлд шалгаруулах**

14.1. Бүрэлдэхүүн/салбар сургуулиуд сүүлийн 5 жилд профессор багшийн гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлтийг гол шалгуур болгон хичээлийн жилийн эцэст дараагийн 3 жилд ажиллах багш нарын албан тушаалын зэрэглэлийг тогтоохдоо үзүүлэлт бүрийг хэрхэн хангасан байдлыг холбогдох нотлох баримт, тайлбарын хамт бүрдүүлж, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар томилогдсон, ашиг сонирхлын зөрчилгүй, тухайн нэгжид харьяалалгүй төлөөлөл бүхий үнэлгээний хороогоор үнэлүүлж, захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрээ МУИС-ийн үнэлгээний хороонд 06-р сарын 01-ны дотор ирүүлнэ. Урт хугацааны томилолтоор ажиллаж буй багш нь үнэлгээний хугацаанд зэрэглэлд тавигдах шаардлага хэрхэн хангасан тухай холбогдох баримт, тайлбарыг үнэлгээний хороонд ирүүлж үнэлгээнд заавал орно. Холбогдох хугацаанд үнэлгээнд ороогүй багш нь томилолтоос эргэн ирэх үед тухайн нэгжид байгаа сул орон тоонд ажиллах бөгөөд уг орон тооны зэрэглэлийн шаардлагыг хангасан байх шаардлагатай.

14.2. МУИС-ийн захирлын тушаалаар томилогдсон үнэлгээний хороо шийдвэрээ 06-р сарын 15-ны дотор МУИС-ийн захиргаанд ирүүлнэ. Багшийн ажиллах албан тушаалын зэрэглэлийг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

14.3. Профессорын зэрэглэлийн нэг орон тоонд уг болзлыг хангасан хэд хэдэн багш байх тохиолдолд олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо, түүнд зохиогчийн оруулсан хувь нэмэр, монограф бүтээл, удирдан хэрэгжүүлсэн судалгааны төсөл зэрэг үзүүлэлтийг харгалzan хавсралт 1 /хүснэгт 2/-д заасны дагуу оноогоор шалгаруулна.

14.4. Профессор, дэд профессорын орон тоонд болзол хангасан багш байхгүй тохиолдолд шаардлагыг бууруулж орон тоог нөхөж ажиллахыг хориглоно.

14.5. Профессор багшийн албан тушаалын зэрэглэлийн шалгаруулалтыг тухайн хичээлийн жилийн төгсгөлд (6 дугаар сарын 15-ны дотор) явуулж, дараагийн хичээлийн жилээс (9 дүгээр сарын 01-ээс) мөрдөнө.

14.6. Энэ журмын 15 дугаар бүлэгт заасан болзлыг бүрэн биелүүлж, профессор, дэд профессор цол авсан бол харгалзах албан тушаалын зэрэглэлд шалгаруулалтгүй ажиллана.

14.7. Профессор, дэд профессороос бусад зэрэглэлд ажиллаж байгаа үндсэн багш нь багшийн ажлын нэгдсэн үнэлгээнд 3 жил тутамд орно.

14.8. Багш нь өөрийн үнэлгээний тайланг хавсралт 2-ын дагуу бичиж, хавсралт 3-т заасны дагуу үнэлүүлнэ.

#### **Арван тав. МУИС-ийн профессор, дэд профессор цол олгох**

15.1. МУИС-ийн профессор, дэд профессор цол олгохоор багш нарын ажлыг үнэлж шалгаруулахдаа өндөр хөгжилтэй орнуудад баримталдаг түгээмэл шалгуур үзүүлэлт, зарчмыг баримтална. МУИС-ийн профессор, дэд профессор цол олгож урт хугацаагаар ажиллуулахдаа хугацаат үнэлгээний систем (tenure track system)-ийг баримтална. Профессор, дэд профессор цол олгох болзлын шалгаруулалтыг тухайн хичээлийн жилийн төгсгөлд (6 дугаар сарын 15-ны дотор) явуулж, дараагийн хичээлийн жилээс (9 дүгээр сарын 01-ээс) мөрдөнө.

15.2. Профессор, дэд профессор цол хүртэхээр нэр дэвшигч багш нар ажлын гол үзүүлэлтүүд болох эрдэм шинжилгээ, сургалт болон сургууль, нийгэмд үзүүлсэн үйлчилгээний чиглэлээр Хавсралт 1-д заасан оноог авсан байх шаардлагатай.

15.3. *Science*, *Nature*, *Cell* г.м. Web of Science IF-JCR импакт фактор нь 20-иос дээш мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор 1 өгүүлэл хэвлүүлсэн тохиолдолд эрдэм шинжилгээний үзүүлэлт бүрэн биелсэнд тооцож болно. Эдгээр оноог тооцоходоо сүүлийн 5 жилийн Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий байгалийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухааны сэтгүүлийн эшлэлийн тайланг үндэслэн тогтооно.

15.4. Инженер, математик, нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын судалгааны оноонд Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий мэдээллийн санд бүртгэгдсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэлд хэвлүүлсэн илтгэл, өгүүлэл, МУИС-ийн нэрээр бүртгүүлсэн патент, захиалгат судалгаа, технологи дамжуулалтын нийлбэр оноог судалгааны онооны 30 хувь хүртэл хүлээн зөвшөөрч болно. Энэ тохиолдолд Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий мэргэжлийн сэтгүүлд мэдээллийн санд бүртгэгдсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэлд хэвлүүлсэн илтгэл, өгүүлэлд өгөх оноог IF-JCR индексгүй боловч мэргэжлийн түвшинд хянаагддаг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлтэй дүйцүүлэн тооцно.

15.5. Хоёр удаа буюу 6 жилийн хугацаагаар профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж, улмаар шаардагдах оноог бүрэн цуглуулсан багш нь харгалзах

МУИС-ийн профессор, дэд профессор цолны болзлыг хангасан гэж үзнэ. МУИС-ийн профессор цолд нэр дэвшигч 2-оос доошгүй докторант удирдаж хамгаалуулсан эсхүл 1 доктор удирдаж хамгаалуулсан бөгөөд хавсралт 1-ийн хүснэгт 1-д заасан эрдэм шинжилгээний оноог хоёр дахин ба түүнээс дээш хувиар давуулан биелүүлсэн байх шаардлагатай. Дэд профессор цолд нэр дэвшигч 5-аас доошгүй магистрант удирдаж хамгаалуулсан байх шаардлагатай. Дэд профессорын цолны болзлын хувьд 1 докторыг 2 магистратай дүйцүүлэн тооцож болно. Профессор, дэд профессор цолд нэр дэвшигч багш нар нь МУИС-ийн докторант, магистрант удирдаж хамгаалуулсан байна.

15.6. МУИС-ийн профессор, дэд профессорын зэрэглэлд тавигдах өрөнхий болон тусгай шаардлагыг бүрэн биелүүлж, цолны шаардагдах оноог бүрэн цуглуулан харгалзах зэрэглэлд хоёр удаа амжилттай ажилласан багшид Эрдмийн зөвлөлөөр батламжлан МУИС-ийн профессор, дэд профессор цол (tenured professor, tenured associate professor) олгоно.

15.7. МУИС-ийн профессор, дэд профессор цолтой багш нь судалгааны суурь зардлаар хангагдах, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу цалингийн нэмэгдэл авах эрх эдэлнэ.

15.8. МУИС-ийн захирал, дэд захирал, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, газар, алба, хэлтсийн даргын албан тушаалд ажилласан хугацааг өмнө ажиллаж байсан зэрэглэлийн дагуу профессор, дэд профессорын зэрэглэлд ажилласан сорилын хугацаанд дүйцүүлж тооцно. Тэд МУИС-ийн профессор, дэд профессорт тавигдах шаардлагыг бусад багшийн адил хангаж, үнэлүүлнэ. Багш нарын хувьд энэ журам хэрэгжиж эхлэхээс өмнөх тухайн албан тушаалын зэрэглэлд ажиллаж байсан хугацаа нь журмын 15.5-д заагдсан хугацаанд орж тооцогдоно.

15.9. Бусад их, дээд сургуулийн олгосон профессор, дэд профессор цолыг МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөс олгосон цолтой дүйцүүлэн тооцохгүй.

15.10. Дэд профессор, профессор цол олгохтой холбоотой аливаа гомдлыг МУИС-ийн Эрдмийн зөвлөлд нарийн бичгийн даргаар уламжлан тавина. Эрдмийн зөвлөлийн даргын шийдвэрээр томилсон комисс гомдлыг 14 хоногийн дотор шалгаж, үр дүнг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

15.11. Профессор, дэд профессор цолыг болзол, шаардлага хангаагүй багшид олгосон нь тогтоогдвол Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар уг шийдвэрийг хүчингүй болгоно.

### **Арван зургаа. Цалингийн сүлжээ**

16.1. Профессор багшийн мэргэжлийн ур чадвар, эрдэм шинжилгээний бүтээл зэрэг үзүүлэлтэд тулгуурлан тогтоосон албан тушаалын зэрэглэл тус бүрд цалингийн ялгаатай сүлжээг баримтална.

16.2. Багш нарын үндсэн цалингийн (эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх мэтийн бусад эх үүсвэрийн орлого хамаарахгүй) сүлжээг багшийн зэрэглэлийн цалинтай харьцуулан тогтооно:

<u>Албан тушаал</u> <u>цалин</u>	<u>Ажилласан жил</u>	<u>Харьцуулсан</u>
1) Профессор	15 жил	135%
2) Дэд профессор	15 жил	120%
3) Ахлах багш	15 жил	105%
4) Багш	7 жил	100%
5) Дадлагажигч багш	2 жил	75%

16.1. Ажлын үнэлгээгээр аливаа багш өмнөх албан тушаалын зэрэглэлээсээ буурч ажиллах бол шинэ зэрэглэлд харгалзах цалинг авна.

\*\*\*      \*\*\*      \*\*\*

1117144746

УХД/072/0104399

**Хүснэгт 1. МУИС-ийн профессор, дэд профессор цол олгоход  
биелүүлбэл зохих оноо**

Албан тушаал	Эрдэм шинжилгээ	Сургалт, нийгмийн үйлчилгээ	Нийт
Дэд профессор	1960	840	2800
Профессор	2450	1050	3500

Тайлбар: Хүснэгтэнд үзүүлсэн оноог бүрэн биелүүлнэ.

**Хүснэгт 2. Эрдэм шинжилгээний үйл ажиллагааг тооцох онооны шатлал**

Эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлтүүд	Оноо
Web of Science IF-JCR импакт фактор индекс бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл <sup>15</sup>	400
Scopus-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл <sup>15</sup>	300
Web of science IF-JCR импакт факторгүй боловч мэргэжлийн түвшинд хянаагддаг /peer-review/ олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл <sup>15</sup>	160
Дотоодод англи хэлээр хэвлэгддэг, мэргэжлийн түвшинд хянаагддаг, олон улсын редакцийн зөвлөл бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл <sup>15</sup>	100
МУИС-д бүртгэлтэй мэргэжлийн түвшинд хянаагддаг эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл <sup>15</sup>	80
МУИС-д бүртгэлгүй боловч дотоодод мэргэжлийн түвшинд хянаагддаг эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл <sup>15</sup>	25
Монограф <sup>16</sup> <ul style="list-style-type: none"> <li>- олон улсын нэр хүнд бүхий хэвлэлийн газраар хянан тохиолдуулсан</li> <li>- бусад гадаад хэл дээрх</li> <li>- Монгол хэлээр</li> </ul>	400 300 200

<sup>15</sup>Хамтын бутээлд оноог тухайн бутээлд зохиогчийн оруулсан хувь нэмрээс хамааруулан 1-р зохиогчид бүтнээр, холбоо барих зохиогчид 0.8-аар үржүүлж, бусад зохиогчдод 0.5-аар үржүүлж тооцно. Өгүүллийг хэвлүүлсэн эсвэл хэвлэхээр зөвшөөрөгдсэн (accepted) тохиолдолд үнэлгээнд тооцож болно. Нэг өгүүлэл нэг удаа үнэлгэдэнэ. Scopus-н хувьд CiteScore үнэлгээз бүхий сэтгүүлд хэвлүүлсэн бутээлийг тооцно.

<sup>16</sup> Гадаад хэлээрх монографыг олон улсын хэвлэлийн индексээр (SPi) тодорхойлох ба тодорхойлох боломжгүй (эсвэл монгол хэл дээр бичигдсэн) тохиолдолд хэвлэлийн газар, редакцийн түвшин, хэвлэгдсэн тоо зэрэгт үндэслэсэн мэргэжлийн эрдэмтэд шинжээчдийн дүгнэлтээр тодорхойлно. Олон зохиогчтой тохиолдолд зохиогчийн оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, тодорхойгүй тохиолдолд багц цагийг бүх оролцогчдод тэнцүү хувааж тооцно. Бусдын монографд бүлэг бичсэн тохиолдолд харгалзах хэвлэлийн хуудсаар тооцогдох багц цагийн хэмжээг 0.5-аар үржүүлж тооцно.

Боловсруулж баталгаажуулсан патент	
- Технологийн патент	200
- Хэвлэмэл бүтээлийн патент <sup>17</sup> /ашигтай загвар	50
Олон улсын байгууллага, гадаадын засгийн газар, эрдэм шинжилгээний сан, их сургууль, компанийн санхүүжилттэй 30 сая төгрөгөөс дээш төсөвтэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл удирдсан бол <sup>18</sup>	200
30 сая төгрөг хүртэл төсөвтэй төсөл удирдсан бол	1117144746 УХД00714399
Төр, засгийн байгууллага, Монгол дахь олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, гэрээт, захиалгат болон МУИС-аас санхүүжүүлсэн 30 сая төгрөгөөс дээш төсөвтэй эрдэм шинжилгээ, судалгааны ажил удирдсан бол <sup>18</sup>	150
30 сая төгрөг хүртэл төсөвтэй төсөл удирдсан бол	100
	80

### Хүснэгт 3. Сургалтын үйл ажиллагааг тооцох онооны шатлал

Сургалт	Хэмжээ	Оноо
Бакалаврын түвшний хичээлийн тодорхойлолт боловсруулах болон сайжруулах <sup>19</sup>	1 хичээл	20
Магистр, докторын хичээлийн тодорхойлолт боловсруулах болон сайжруулах <sup>19</sup>	1 хичээл	35
БСШУСЯ, МУИС-ийн болон их, дээд сургуулийн консорциумын шилдэг багшийн шагнал авах	1 шагнал	50
Сурах бичиг <sup>20</sup> - орчуулгын бүтээл (зохиогчоос эрх авсан байх)	1 сурах бичиг	150 75
Удирдаж хамгаалуулсан магистрын тоо	1 магистрант	30
Удирдаж хамгаалуулсан докторын тоо	1 докторант	60
Гадаад оюутан болон тусгай хөтөлбөрөөр суралцагчийг удирдах	1 хөтөлбөр 1 гадаад оюутан	15 10
Цахим хичээл боловсруулах	1 хичээл (1багц цаг)	30
Цахим хичээл заах	1 хичээл	20
Дотоодын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг бичилцсэн бол	1 хөтөлбөр	20
Гадаадын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг бичилцсэн бол	1 хөтөлбөр	40

<sup>17</sup> Хэвлэмэл бүтээлийг тусад нь үнэлгээнд оруулсан тохиолдолд патентийг давхардуулан тооцохгүй.

<sup>18</sup> Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлуудын санхүүжилт нь МУИС-ийн дансаар шилжин орж зарцуулаадсан байх шаардлагатай.

<sup>19</sup> Хичээлийн тодорхойлолт боловсруулах болон сайжруулах ажилд багаар ажшигласан бол нийт оноог бүх оролцогчдод тэнцүү хуваана.

<sup>20</sup> Сурах бичиг, орчуулгын бүтээл нь бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлөөр зөвшиөөрөгдсөн байх ба олон зохиогчийн тохиолдолд зохиогчдын оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, хэрэв зохиогчдын оролцоо тодорхойгүй бол оноог бүх оролцогчдод тэнцүү хуваана.

**Хүснэгт 4. Сургууль, нийгэмд үзүүлэх үйлчилгээг тооцох онооны шаталал**

Сургууль, нийгэмд үзүүлэх үйлчилгээ	Хэмжээ	Оноо
МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий болон дэд хорооны гишүүнээр ажиллах	1 хичээлийн жил	20
МУИС-ийн болон сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллах (давхардуулж тооцож болно)	1 хичээлийн жил	10
Их сургуулийн болон бүрэлдэхүүн/салбар сургуулийн аль нэг хорооны гишүүнээр, их семинар удирдаж ажиллах	1 хичээлийн жил	20
Сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэгт орж ажиллах, бусад үүрэгт ажил хийж гүйцэтгэх	1 удаа	20
Улсын хэмжээнд олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах, сургалт семинар удирдах, оролцох	1 удаа	10
Эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	1 удаа	10
Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	1 удаа	25
Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	1 удаа	15
Телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	1 удаа	10
МУИС-ийн төгсөгчдийн холбооны ажилд оролцох	1 хичээлийн жил	20
Мэргэжлийн холбоодын удирдах зөвлөлд болон гишүүнээр ажиллах	1 хичээлийн жил	15

## Багшийн ажлын өөрийн үнэлгээний тайланг бичих заавар

Багшийн ажлын нэгдсэн үнэлгээнд орж буй багш энэ зааврыг баримтлан тайлан бичиж, багшийн үндсэн З төрлийн ажилд холбогдох зохих нотпох баримтуудын бурдуулж (зарим онцлог зүйлийг ялган тэмдэглэнэ) ~~уухан~~ хавсаргасан байна. Мөн цаашдын зорилт, төлөвлөсөн ажлаа бичиж, нэгдсэн үнэлгээнд ороогүй онцлог ажил, ажлынхаа дуусгасан болон явцын, төлөвлөсөн үр дүнг тусгасан тайлбар нэмж болно.

Овог нэр: \_\_\_\_\_

Сургууль: \_\_\_\_\_

Тэнхим: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

Тухайн албан тушаалд ажилласан жил: \_\_\_\_\_

Цалингийн эх үүсвэр: МУИС-иас (... %) Бусад (бичих) (... %)

Тайлангийн үндсэн хэсэгт багшийн ажлыг үнэлэх чиглэлүүдийн дагуу

- Сургалт, заах арга зүй,
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил,
- Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэсэн ажил гэсэн дэд хэсэг бүрээр гүйцэтгэсэн ажлаа тодорхой бичнэ.

Төгсгөлд нь боловсрол, мэргэжил дээшлүүлсэн болон гадаад хэл эзэмшсэн байдал, ажлын туршлага зэргийг багтаасан товч намтар (CV), бүтээлийн жагсаалт, ажлын төлөвлөгөө, зорилгоо тодорхойлон бичиж хавсарган, гарын үсгээ зурна.

Багшийн ажлыг үнэлэх үндсэн чиглэлүүд:

### 1. Сургалт, заах арга зүй

#### 1.1 Сургалтын ажил (30%)

1.1.1. Хичээлийн хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэстэй, боловсролын хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсруулах, хөгжүүлэх;

1.1.2. Хичээлийн агуулгыг өмнөх болон залгамж хичээлтэй уялдуулж шинжлэх ухааны үндэстэй боловсруулах;

1.1.3. Сургалтын хөтөлбөрийн болон хичээлийн үнэлгээг сургалтын чанарыг сайжруулахад тасралтгүй хэрэглэх;

1.1.4. Холбогдох дүрэм журмын дагуу суралцагчийг үнэлэх үнэлгээний зарчмыг боловсруулж, үр дүнг цаашдын сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх;

1.1.5. Хичээлийн үнэлгээний даалгаварт задлан шинжилгээ хийж, сургалтын агуулга, арга зүйг сайжруулахад хэрэглэх;

1.1.6. Хичээлийн агуулга, зорилгод тохируулан суралцагчийн мэдлэг, чадварыг олон төрлийн арга, хэлбэрээр үнэлэх, баяжуулах;

1.2 Суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн (интернет, мэдээллийн технологи, дууриах (симуляци), асуудал шийдвэрлэх, тоглоомын арга,

тодорхой тохиолдлын судалгаа (кейс) г.м) сургалтын шинэлэг аргыг нэвтрүүлэх.

### **1.3 Сургалтын технологи ба хэрэглэгдэхүүн (30%)**

1.3.1 Суралцагчийн сэтгэл ханамжийн асуулгын үр дүнд үндэслэн өөрийн заах арга зүй, ур чадвараа үнэлэх, бие даан хөгжүүлэх;

1.3.2 Хичээлийн суралцахуйн үр дүн, сургалтын нөхцөл байдалд тохируулан сургалтын олон талт хэрэглэгдэхүүнийг сонгох, хэрэглэх;

1.3.3 Суралцагчийн бие даан болон багаар суралцахуйг дэмжсэн сургалтын онцлог, нөхцөл байдлаас хамааруулан сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгох, бүтээлчээр хэрэглэх, судалгааны үр дүнг сургалтын хэрэглэгдэхүүн болгон хэрэглэх;

1.3.4 Сургалтын хэрэглэгдэхүүн (лекц, семинар, лаборатори, дадлага гэх мэт)-ийг МУИС-ийн сургалтын цахим хуудсанд байршуулж, суралцагчдад нээлттэй хэрэглэх боломжийг бүрдүүлэх;

1.3.5 Хичээл, сургалтад мэдээлэл харилцаа, технологийн дэвшилтэт арга, техник хэрэгсэл ашиглах.

### **1.4 Суралцагчтай ажилласан байдал (30%)**

1.4.1 Хичээлийн бус цагт тодорхой хуваариар суралцагчдад сургалтын талаар зөвлөгөө өгөх, бие даан суралцах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

1.4.2 Суралцагчдад судалгааны ажилд үүсч буй асуудлын шийдлийг олж харах, сорилтыг даван туулахад туслах;

1.4.3 Клуб, дугуйлан удирдан хичээллүүлэх;

1.4.4 Сургалтад интерактив орчин бүрдүүлэх, урамшуулах, сэдэлжүүлэх замаар багш, суралцагчдын суралцахуйг дэмжих;

1.4.5 Суралцагчдын суурь мэдлэг, оюун ухаан, хүсэл сонирхол, сурах арга, барил, хувь хүний хөгжлийн шат харилцан адилгүй байдлыг сургалтын явцад тусгах.

### **1.5 Даалгаварт болон бусад ажил (10%)**

1.5.1 Бакалаврын оюутны судалгааны ажил болон магистрантын дипломын ажилд шүүмж өгөх, болзлын шалгалт авах комисст ажиллах;

1.5.2 Сургалтын арга технологийг боловсронгуй болгох, шинэчлэхтэй холбоотой тусгайлсан даалгавар гүйцэтгэх

1.5.3 Элсэлт, төгсөлтийн ажил зохион байгуулахад оролцох;

1.5.4 Заах арга зүйн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх.

## **2. Эрдэм шинжилгээний ажил**

### **2.1 Эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл (60%)**

2.1.1 Мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;

2.1.2 Сургуулийн, үндэсний болон олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлэх;

2.1.3 Докторын зэрэг горилсон бүтээл туурвих;

2.1.4 Шинжлэх ухааны онолын болон судалгааны баг, их семинарт судалгааны үр дүнгээ тогтмол хэлэлцүүлэх;

2.1.5 Зохиогчийн эрхээр баталгаажуулсан бүтээл (ном, сурах бичиг) туурвих.

## **2.2 Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажил, оюуны өмчийн бүтээл (20%)**

2.2.1 Шинэ бүтээл, оновчтой санал гаргаж, эрхийн хамгаалалт хийлгэх, патент, стандарт, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, зохиогчийн эрх авах, үйлдвэрлэлд технологи нэвтрүүлэх;

2.2.2 Эрдэм шинжилгээний төсөл, захиалгат болон гэрээт ажил, инновацийн төсөлд туслах болон үндсэн судлаачаар оролцох.

### **2.3 Эрдэм шинжилгээний бусад ажил (20%)**

2.3.1 Оюутан, магистрантын эрдэм шинжилгээний ажлыг удирдах, судалгааны арга зүйн зөвлөмж өгөх;

2.3.2 МУИС-ийн мэдээллийн системд өөрийн эрдэм шинжилгээний бүтээлийг оруулах;

2.3.3 Үндэсний нийгэмлэг, хороо, зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох;

2.3.4 Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлийн хянан магадлагчаар ажиллах.

## **3. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ**

### **3.1 Мэргэжлийн үйлчилгээ (50%)**

3.1.1 Эрдэм шинжилгээний хялбаршуулсан болон сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх;

3.1.2 Сургалтын үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ, санал өгөх;

3.1.3 Эрдэм шинжилгээний лаборатори, кабинет, тоног төхөөрөмж, мэдээллийн сан хариуцан ажиллах;

3.1.4 Сургалт хариуцсан нэгж, тэнхимиийн эрхлэгчийн даалгавраар багшийн хичээлд сууж, дагалдан суралцах;

3.1.5 Сургуулийн захиргааны шийдвэрээр заавар, дүрэм, журам, бусад баримт бичиг боловсруулах, хяналт шалгалтад оролцох, оюутны байгууллагын үйл ажиллагаанд туслах;

3.1.6 Улсын болон сургууль, тэнхимиийн хэмжээнд олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах;

3.1.7 Мэргэжлийн холбоод, комисс, зөвлөлд томилолтын болон сонгуульт албан тушаал гүйцэтгэх;

3.1.8 Зөвлөх багшаар ажиллах, оюутны соёл, олон нийтийн ажил зохион байгуулах зэргээр суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажилд оролцох;

3.1.9 Олон улсын болон улсын хэмжээний хурал, уулзалт семинар зохион байгуулах

3.1.10 Төр, засгийн бодлого, шийдвэрийн төсөлд шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар бодлогын баримт бичиг, илтгэл, төсөл боловсруулах;

3.1.11 Аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр мэргэжлийн зөвлөгөө өгөх;

3.1.12 Мэргэжлийн болон спорт, урлагийн хамтлаг удирдах, уралдаан тэмцээнд оролцох.

### **3.2 Нийгмийн үйлчилгээ (50%)**

3.2.1 Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шинжлэх ухаан, танин мэдэхүйн

чиглэлээр сурталчилгаа хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.2.2 Өдөр тутмын сонин, хэвлэлд өгүүлэл, нийтлэл хэвлүүлэх;

3.2.3 МУИС-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийн дагуу төрөл бүрийн сургалт явуулахад оролцох, зохион байгуулах;

3.2.4 Нийгэм, ард иргэдийн дунд сургуулийн нэр хүндийг өргөхөд хувь НЭМЭР  
оруулахуйц бусад ажил гүйцэтгэх;

3.2.5 Сургуульд тодорхой хэмжээний орлого оруулах ажил гүйцэтгэх;

3.2.6 Байгууллага, иргэдэд боловсрол, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх,  
эрдэм, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах;

3.2.7 ЕБС-ийн сурагчдын авьяасыг нээн илрүүлж, дэмжих.

**Багшийн ажлын нэгдсэн үнэлгээний агуулга, аргачлал**

Багшийн ажлыг дараах 3 чиглэлээр үнэлнэ. Үүнд:

- а) сургалт, заах арга зүй;
- б) эрдэм шинжилгээний ажил;
- в) мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ.

Багшийн нийт гүйцэтгэвэл зохих үүрэгт ажлыг 100 оноогоор дүгнэх бөгөөд багшийн албан тушаалын зэрэглэлээс хамаарч үндсэн 3 чиглэлээр онооны хуваарилалт нь дараах хүснэгтэд заасан хэмжээтэй байна.

*Багшийн албан тушаалын зэрэглэл, гүйцэтгэх үндсэн ажилд харгалзах оноо*

Багшийн албан тушаалын зэрэглэл	Сургалт, заах арга зүй	Эрдэм шинжилгээ	Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ
Ахлах багш	45	35	20
Багш	50	30	20

Багшийн ажлын үнэлгээг хичээлийн жилийн туршид тодорхой хуваарийн дагуу

- Оюутны үнэлгээ;
- Комиссын үнэлгээ;
- Удирдлагын үнэлгээ өгөх гэсэн шатлалтай явуулна.

Багшийн гүйцэтгэх ажлын үндсэн төрөл, ажлыг үнэлэгчид, тэдний үнэлгээний дүнд эзлэх хувийг дараах хүснэгтэд харуулав.

Гүйцэтгэх ажлын төрөл	Оюутны үнэлгээ	Комиссын үнэлгээ	Удирдлагын үнэлгээ
a. Сургалт, заах арга зүй	50%	30%	20%
b. Эрдэм шинжилгээ	-	55%	45%
c. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ профессор, дэд профессор, зөвлөх профессоруудаас бүрдүүлнэ. Сургалт, заах арга зүйн чиглэлээр удирдлагын үнэлгээг өгөхдөө сургалт хариуцсан нэгжээс ирүүлсэн мэдээ баримтад үндэслэнэ.	-	40%	60%
c. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ			

Үнэлгээний комиссыг тухайн салбарын профессор, дэд профессор, зөвлөх профессоруудаас бүрдүүлнэ. Сургалт, заах арга зүйн чиглэлээр удирдлагын үнэлгээг өгөхдөө сургалт хариуцсан нэгжээс ирүүлсэн мэдээ баримтад үндэслэнэ.

Тооцоог гаргахдаа үнэлэгчээс өгсөн оноог хүснэгтэд заасан хувиар харгалзуулан үржүүлж хооронд нь нэмнэ. Тухайлбал, ахлах багшийн сургалт, заах арга зүйн ажлын үнэлгээнд үнэлэгч бурийн өгч болох дээд оноо 45 байх бөгөөд оюутны үнэлгээ 35, комисс 30, мэргэжлийн удирдлага 36 оноогоор тус тус дүгнэсэн гэвэл багш сургалтын ажлаар авбал зохих 45 онооноос  $a = 35 \times 0.5 + 30 \times 0.3 + 36 \times 0.2 = 33.7$  оноо авлаа гэсэн үг юм.

1117144746  
УХД0072 9104399

a. Сургалт, заах арга зүй: дээд оноо \_

1. Оюутны үнэлгээ, a1 (50%) \_\_\_\_\_
2. Комиссын үнэлгээ, a2 (30%) \_\_\_\_\_
3. Удирдлагын үнэлгээ a3 (20%) \_\_\_\_\_

Авах оноо:  $a = a1 \times 0.5 + a2 \times 0.3 + a3 \times 0.2 =$  \_\_\_\_\_

b. Эрдэм шинжилгээ: дээд оноо .

1. Комиссын үнэлгээ, b2 (55%) \_\_\_\_\_
2. Удирдлагын үнэлгээ, b3 (45%) \_\_\_\_\_

Авах оноо:  $b = b2 \times 0.55 + b3 \times 0.45 =$  \_\_\_\_\_

c. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ: дээд оноо .

1. Комиссын үнэлгээ, c2 (40%) \_\_\_\_\_
2. Удирдлагын үнэлгээ, c3 (60%) \_\_\_\_\_

Авсан оноо:  $c = c2 \times 0.4 + c3 \times 0.6 =$  \_\_\_\_\_

Нэгдсэн үнэлгээний дүн:  $a + b + c =$  \_\_\_\_\_

- A (90-100): Ийм үнэлгээ авсан багшийн ажлын үр дүнг хангалттай сайн гэж үзнэ. Уг багшид зохих урамшуулалт олгож болох ба асуудлыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөл шийдвэрлэнэ.
- B (70-89): Эрхэлсэн ажилдаа тэнцэж байна гэж үзнэ.
- C (70-79): Ажилдаа тэнцэж байна гэж үзэх боловч тухайн багшид бага оноо авсан ажлын үзүүлэлтээ сайжруулах хугацаатай даалгавар өгнө.
- D (60-69): Ажлын үзүүлэлт хангалтгүй гэж үзэх ба албан тушаалыг нь нэг зэрэглэлээр бууруулж, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргаанаас тухайн багшид нэг жилийн хугацаатай даалгавар өгч, дараагийн хичээлийн жилийн үнэлгээнд дахин орох боломж олгоно. Энэ үндэслэлээр зэрэглэл буурсан багшийн хувьд дараагийн үнэлгээний үр дүнгээр өмнөх зэрэглэлдээ дэвшин ажиллах эрх нь хадгалагдана. Дахин үнэлгээнд орохоос татгалзвал хөдөлмөрийн гэрээг цуцална.
- F (60-аас доош): Ажлын гүйцэтгэл нь зохих минимум шаардлагын түвшинд хүрээгүй, маш хангалтгүй ажилласан гэж үзнэ. Ийм үнэлгээ авсан багшийн хөдөлмөрийн гэрээг цуцална.

Үнэлгээний тайландаа заасан буюу шаардсан бичиг баримтыг өөрөө бүрдүүлж өгөөгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр үнэлгээнд хугацаандаа ороогүй, орохоос зайлсхийсэн багшийг D үнэлгээ авсантай адилтган үзэж албан тушаалын зэрэглэлийг нь бууруулна.

-----000-----